



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/205

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271^{1.1.1}, 271^{1.1.12} дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, Гаалийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл, Мэдээлэл холбооний сүлжээ ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 01/41 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансад бүртгэлтэй Гаалийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын 2020-2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн “Хилийн боомтууд дахь гаалийн байгууллагын зарим салбарыг шилэн кабелийн сүлжээнд холбох” ажлын улсын комиссийн актыг үндэслэн гүйцэтгэлийг харьяа гаалийн газар, хороодын балансад хавсралт ёсоор шилжүүлсүгэй.
2. Хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Дорнод аймаг дахь гаалийн газар /Б.Гэрэлт-Од/-т, Сайншанд дахь гаалийн газар /А.Оргил/-т, Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороо /Д.Эрдэнэсүх/-т, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороо /Р.Цэрэндорж/-т тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АСРАЛТ

• 1439501 2890

Гаалийн ерөнхий газрын даргын
 2022 оны 10 дугаар сарын 05-ны
 өдрийн /105/ дугаар тушаалын хавсралт



Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансаас харьяа гаалийн газар, хороодын балансад шилжүүлэх улсын комиссийн гүйцэтгэлээрх шилэн кабелийн сүлжээний жагсаалт

/төгрөгөөр/

№	Эзэмшиж буй газар, хороо	Хөрөнгийн нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Харьяа гаалийн газар, хороод
1	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Шилэн кабелийн сүлжээнд холбох /Эрэнцав/	км	5.8	105,072,348.00	Дорнод аймаг дахь гаалийн газар
2		Шилэн кабелийн сүлжээнд холбох /Баянхошуу/	км	304.9	2,498,214,896.00	Дорнод аймаг дахь гаалийн газар
3		Шилэн кабелийн сүлжээнд холбох /Ханги/	км	262.8	1,860,446,106.00	Сайншанд дахь гаалийн газар
4		Шилэн кабелийн сүлжээнд холбох /Бургастай/	км	74.8	636,935,689.00	Говь-Алтай аймаг дахь гаалийн хороо
5		Шилэн кабелийн сүлжээнд холбох /Арц суурь/	км	44.4	397,453,678.00	Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороо
			НИЙТ		5,498,122,717.00	